

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/23/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Х.Манаргүл Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Төсвийн захирагч

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,960,174.40</u>	<u>95,350,877.00</u>
33	АВЛАГА	-	38,330,500.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	38,330,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,960,174.40	57,020,377.00
351	Түүхий эд материал	28,444,525.40	34,560,200.00
35110	Тусгай зориулалттай материал	12,260,780.00	13,988,330.00
35130	Эм боох материал	16,183,745.40	20,571,870.00
354	Хангамжийн материал	28,515,649.00	22,460,177.00
35410	Бичиг хэргийн материал	1,141,670.00	1,284,670.00
35420	Аж ахуйн материал	7,209,217.00	10,305,505.00
35430	Сэлбэг хэрэгсэл	610,000.00	-
35450	Барилгын засварын материал	3,037,400.00	695,000.00
35460	Хүнсний материал	1,920,960.00	1,814,220.00
35470	Бусад хангамжийн материал	14,596,402.00	8,360,782.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>697,399,802.58</u>	<u>722,728,957.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	697,399,802.58	722,728,957.92
392	Биет хөрөнгө	692,039,002.58	717,368,157.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	619,176,800.00	629,176,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,165,943.88)	(33,367,249.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,739,996.00	63,559,996.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,320,333.05)	(25,130,665.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,914,278.00	107,282,533.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,134,793.77)	(42,919,674.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,122,909.00	30,275,351.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,293,909.72)	(11,508,933.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,751,993.00	15,751,993.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,751,993.00)	(15,751,993.00)
393	Биет бус хөрөнгө	5,360,800.00	5,360,800.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,360,800.00	5,360,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>754,359,976.98</u>	<u>818,079,834.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>23,094,400.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	23,094,400.00
413	Өглөг	-	23,094,400.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	16,542,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	6,552,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>754,359,976.98</u>	<u>794,985,434.92</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	754,359,976.98	794,985,434.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	452,687,965.00	452,687,965.00
51101	Өмч: - төрийн	452,687,965.00	452,687,965.00
512	Хуримтлагдсан үр дүн	(48,255,029.70)	(6,575,540.76)
51210	Өмнөх үеийн үр дүн	(48,255,029.70)	(47,200,998.70)
51220	Тайлант үеийн үр дүн	-	40,625,457.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	349,927,041.68	348,873,010.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	754,359,976.98	818,079,834.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	563,761,428.00	740,116,272.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,163,700.00	20,655,540.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,163,700.00	20,655,540.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,163,700.00	20,655,540.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,163,700.00	20,655,540.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	555,597,728.00	719,460,732.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	460,688,396.00	502,706,221.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	61,749,996.00	27,949,821.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,938,400.00	474,756,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,903,472.00	101,158,411.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,201,761.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,701,711.00	101,158,411.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,025,000.00	44,579,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,025,000.00	21,779,800.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	22,800,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	36,980,860.00	71,016,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,980,860.00	71,016,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	515,107,681.87	699,269,614.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515,107,681.87	699,269,614.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,887,681.87	664,119,614.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,693,065.00	402,182,560.00
210101	Үндсэн цалин	221,313,099.00	246,356,257.00
210102	Нэмэгдэл	89,829,800.00	91,309,103.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,300,000.00
210104	Урамшуулал	21,550,166.00	47,057,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	11,160,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,846,000.00	55,263,750.00

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	31,841,800.00	40,965,650.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,251,100.00	3,574,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,600,800.00	2,859,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,200.00	714,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,502,100.00	7,149,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,771,200.00	20,895,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,630,700.00	1,630,700.00
210302	Түлш, халаалт	27,140,500.00	19,264,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,783,727.00	49,054,790.00
210401	Бичиг хэрэг	2,560,250.00	2,650,930.00
210402	Тээвэр, шатахуун	22,948,650.00	29,672,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,180,600.00	1,621,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,910,610.00	4,688,590.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,153,117.00	8,162,170.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,030,500.00	2,259,400.00
2105	Нормативт зардал	35,829,540.00	81,619,098.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,680,850.00	62,480,408.40
210502	Хоол, хүнс	8,384,690.00	12,851,440.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	764,000.00	6,287,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,598,770.00	11,532,650.00
210604	Урсгал засвар	3,598,770.00	11,532,650.00
2107	Томилолт, зочны зардал	516,000.00	3,247,200.00
210702	Дотоод албан томилолт	516,000.00	3,247,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	437,600.00	1,083,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,200.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	85,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	198,000.00
210807	Газрын төлбөр	50,700.00	50,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	69,300.00	396,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,411,779.87	39,240,766.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,011,240.00	3,691,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,400,539.87	35,549,266.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,000.00	35,150,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,150,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	25,150,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	220,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	220,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	48,653,746.13	40,846,657.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	221,199.64
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	221,199.64

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(221,199.64)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	48,653,746.13	40,625,457.94

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,687,965.00	349,927,041.68	(48,255,029.70)	754,359,976.98
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	452,687,965.00	349,927,041.68	(48,255,029.70)	754,359,976.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,054,031.00	1,054,031.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	452,687,965.00	349,927,041.68	(47,200,998.70)	755,414,007.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(1,054,031.00)		(1,054,031.00)
D08	Тайлант үеийн үр дүн			40,625,457.94	40,625,457.94
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,687,965.00	348,873,010.68	(6,575,540.76)	794,985,434.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	493,847,732.00	630,380,411.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,847,732.00	630,380,411.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	398,938,400.00	474,756,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,938,400.00	474,756,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,903,472.00	101,158,411.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,201,761.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,701,711.00	101,158,411.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,025,000.00	21,779,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,025,000.00	21,779,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	36,980,860.00	32,685,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,980,860.00	32,685,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	492,347,732.00	620,030,611.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,347,732.00	620,030,611.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	492,127,732.00	584,880,611.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,693,065.00	387,478,560.00

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	221,313,099.00	246,356,257.00
210102	Нэмэгдэл	89,829,800.00	91,309,103.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,300,000.00
210104	Урамшуулал	21,550,166.00	32,353,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	11,160,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,846,000.00	53,425,750.00
210201	Тэтгэврийн даатгал	31,841,800.00	39,127,650.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,251,100.00	3,574,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,600,800.00	2,859,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,200.00	714,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,502,100.00	7,149,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,855,800.00	20,895,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,630,700.00	1,630,700.00
210302	Түлш, халаалт	28,225,100.00	19,264,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,137,800.00	37,735,700.00
210401	Бичиг хэрэг	1,318,500.00	2,646,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,893,400.00	26,869,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,180,600.00	1,621,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,745,300.00	3,388,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,210,000.00
2105	Нормативт зардал	39,983,029.00	68,047,001.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,546,629.00	53,394,601.00
210502	Хоол, хүнс	7,284,400.00	12,637,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,000.00	2,014,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,432,177.00	7,209,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,792,977.00	2,825,600.00
210602	Тавилга	-	4,384,200.00
210604	Урсгал засвар	1,639,200.00	-
2107	Томилолт, зочны зардал	516,000.00	3,247,200.00
210702	Дотоод албан томилолт	516,000.00	3,247,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	437,600.00	1,083,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,200.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	85,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	198,000.00
210807	Газрын төлбөр	50,700.00	50,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	69,300.00	396,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,226,261.00	5,757,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,226,261.00	5,757,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,000.00	35,150,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,150,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		25,150,000.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	220,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	220,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,500,000.00	10,349,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,500,000.00	10,349,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,500,000.00	10,349,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,500,000.00	10,349,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	10,349,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,500,000.00)	(10,349,800.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	529,404,000.00	529,404,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529,404,000.00	529,404,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	529,254,000.00	529,254,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,634,000.00	357,634,000.00
210101	Үндсэн цалин	215,687,700.00	216,329,697.00
210102	Нэмэгдэл	91,951,100.00	91,309,103.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	6,300,000.00
210104	Урамшуулал	32,535,200.00	32,535,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,160,000.00	11,160,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,255,900.00	48,255,900.00
210201	Тэтгэврийн даатгал	33,957,800.00	33,957,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,574,500.00	3,574,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,859,600.00	2,859,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	714,900.00	714,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,149,100.00	7,149,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,895,600.00	20,895,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,630,700.00	1,630,700.00
210302	Түлш, халаалт	19,264,900.00	19,264,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,909,000.00	34,909,000.00
210401	Бичиг хэрэг	2,382,000.00	2,382,000.00
210402	Тээвэр, шатахуун	25,159,000.00	25,159,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,521,600.00	1,521,600.00

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,086,400.00	3,086,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,760,000.00	2,760,000.00
2105	Нормативт зардал	47,755,700.00	47,755,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,443,300.00	33,443,300.00
210502	Хоол, хүнс	12,297,600.00	12,297,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,014,800.00	2,014,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,909,800.00	4,909,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,025,600.00	4,025,600.00
210604	Урсгал засвар	884,200.00	884,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,903,200.00	1,903,200.00
210702	Дотоод албан томилолт	1,903,200.00	1,903,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,643,400.00	8,643,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	290,000.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	85,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	44,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,758,200.00	7,758,200.00
210807	Газрын төлбөр	50,700.00	50,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	396,500.00	396,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,347,400.00	4,347,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,347,400.00	4,347,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,000.00	150,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,000.00	150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	150,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	529,222,000.00	529,222,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	474,756,400.00	474,756,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	474,756,400.00	474,756,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,779,800.00	21,779,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	21,779,800.00	21,779,800.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,685,800.00	32,685,800.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	32,685,800.00	32,685,800.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.00	27.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21.00	21.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	101,158,411.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	101,158,411.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	66,158,411.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	30,026,560.00
210101	Үндсэн цалин	-	30,026,560.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	5,169,850.00
210201	Тэтгэврийн даатгал	-	5,169,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,826,700.00
210401	Бичиг хэрэг		264,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,710,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		302,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		450,000.00
2105	Нормативт зардал	-	20,291,301.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		19,951,301.00
210502	Хоол, хүнс		340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,500,000.00
210604	Урсгал засвар		3,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,344,000.00
210702	Дотоод албан томилолт		1,344,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	35,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		25,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	101,158,411.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	101,158,411.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		101,158,411.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн зорилго нь: Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, чанартай, хүртээмжтэй, чирэгдэл хүлээгдэлгүй үр дүнтэй үзүүлэх

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

- Хамт олны оролцоог хангах
- Үйлчлүүлэгчдийг дээдлэх
- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах
- Ил тод нээлттэй байх
- Шинэ санаа санаачилгыг дэмжих

Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд тайлант онд ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 515.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63.7 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	38,330.5	38,330.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	56,960.2	57,020.4	60.2
Үндсэн хөрөнгө	697,399.8	722,729.0	25,329.2
Нийт хөрөнгө	754,360.0	818,079.8	63,719.9
Өр төлбөр	-	23,094.4	23,094.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	754,360.0	794,985.4	40,625.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	754,360.0	818,079.8	63,719.9

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл оны эцэст 38.3 сая төгрөг болж өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах Ковид-19 цар тахлын улаан бүсд ажилласан ажилчдын урамшуулал болон бараа үйлчилгээний зардлын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 57.0 сая төгрөг болж 0.1 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 115.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 10.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 0.5 сая төгрөгийн багийн эмч нарын багц, сумын ОНХСангаас 6.0 сая төгрөгийн зөөлөн эдлэл, сумын орон нутгийн давсан орлогоос 3.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бүгд 136.4 сая төгрөгийн бараа

материалыг орлого авч, 128.4 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна. Сумын ИТХурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 35 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2.6 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, 0.4 сая төгрөгийн аж ахуйн материал, дугааргүй хавсралтаар 4.1 сая төгрөгийн, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 тоот тогтоолоор актлагдсан 0.8 сая төгрөгийг, бүгд 7.9 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө 25.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ЭМЯ-наас 27.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сумын ОНХС-гаас ЭМТ-ийн хүнс, аж ахуйн склад 10.0 сая төгрөг, багийн эмчид 2.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 10.0 сая төгрөгийн тавилга эд хогшил, бүгд 61.1 сая төгрөгийн орлого авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 133 тоот тогтоолоор 6.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 4.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, бүгд 11.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгөд 35.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Оны эхэнд өглөггүй гарсан ба оны эцэст Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 цар тахлын өвчнөөр өвдсөн гэрээр болон хэвтэн эмчлүүлэгсэдийн шууд ба шууд бус зардлын санхүүжилт дутуу авсантай холбоотой 23.1 сая төгрөгийн өр шинээр үүссэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 794.9 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 40.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийг 529.2 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 529.2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаанд 529.2 сая төгрөг зарцуулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс 474.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 21.8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 32.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зарлагын 76.7 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 23.3 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Эрүүл мэндийн яамны 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 4/153 дугаар албан бичгээр хөдөөгийн хүн амд эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, эмийн мэргэжилтний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бий болгох зорилгоор Эрүүл мэндийн яамны 2017 оны удирдлагын зөвлөлийн хурлаас “Эмийн эргэлтийн сан”-г сумын Эрүүл мэндийн төвд шилжүүлэх тухай зөвлөмжийн дагуу батлагдсан орон тоогүй мөртлөө сумын Эргэлтийн эмийн сангийн эрхлэгчийг цалингийн доод хэмжээгээр цалинжуулж ажиллуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нийт 101.2 сая төгрөгийг нэмэлт дансаар хүлээн авсан байна. Үүнд аймгийн Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496 , А/585 тоот тушаалуудаар Ковид-19-ын эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулал, нэг удаагийн тэтгэмжид 35.0 сая төгрөгийн, албан томилолтод 1.3 сая төгрөгийн, сумын ОНХС-гаас тээврийн хэрэгсэл болон сэлбэг хэрэгсэлд 6.5 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 цар тахлын өвчнөөр өвдсөн гэрээр болон хэвтэн эмчлүүлэгсэдийн шууд ба шууд бус зардлын санхүүжилтээс 58.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Нэмэлт санхүүжилтээс зарцуулсан зардлыг задалж үзэхэд Ковид-19 цар тахлын үед ажилласан ажиллагсадын цалин, урамшуулалд 35.2 сая, бичиг хэрэгт 0.2 сая, тээвэр шатахуунд 1.7 сая, шуудан холбоо интернетийн мөнгөд 0.1 сая, эм, эмнэлгийн хэрэгсэлд 20.0 сая, хоол хүнсэнд 0.3 сая, урсгал засвард 3.7 сая, дотоод албан томилолт 1.3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 3.6 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшалд 35.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар Алтай сумын Эрүүл мэндийн төвийн аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй боловч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн төвд 2016-2020 онд эмийн санчаар ажиллаж байсан Т.Туяагийн нэр дээр бүртгэлтэй байсан 48 төрлийн 5564.7 мянган төгрөгийн эмийг “2016-2021 оны 6 жилийн хугацаа дууссан эм” хавсралтаар хууль зөрчиж акталсныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Мөн Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ыг мөрдөж ажиллаагүй байгаа талаар албан шаардлага хүргүүлж, сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитын тайланд тусгахаар болов.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 630.4 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 529.2 сая төгрөгийн 103 мэдээллийг хугацаандаа байршуулж, 14 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш гүйлгээ гараагүй байна. Өр, авлагын мэдээллийг хугацаанд байршуулсан байна. Шилэн дансны мэдээллийн мэдээлсэн байдлын дундаж 91.7 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 3 зөвлөмж өгөгдсөний биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж төсвийн зарцуулалт, эмийн тооцоог бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **8.3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.1 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 4.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 4.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Алтай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 35 дугаар тогтоолоор тус Эрүүл мэндийн төвд 2016-2020 онд эмийн санчаар ажиллаж байсан Т.Туяагийн нэр дээр бүртгэлтэй байсан 44 төрлийн 2,808,000 төгрөгийг төгрөгийн эмийг “2016-2021 оны 6 жилийн хугацаа дууссан эм”, эмийн санч Х.Улжаны

хариуцсан 19 төрлийн 1,280,100 төгрөгийн эмийг “ЭМТ-ийн эмийн сангаас хугацаа дууссан эмийн жагсаалт” баталсан хавсралтыг үндэслэн акталж данс бүртгэлээс хассан байна.

Ингэхдээ тухайн эмүүдийн хугацаа дуусан, хэрэглэх боломжгүй болох талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй, устгалт хийсэн тэмдэглэл байхгүй, устгал хийснийг зурагжуулсан нотлох баримт байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”* 16 дугаар зүйлийн 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”*, 16.5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д *“эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт”*, 6.3-т *“Энэ хуулийн 6.2-т заасан зохицуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ”* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 13.5-т *“Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”*, 13.7-т *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, 14 дүгээр зүйлийн 14.4-д *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”*, 14.4.1 *“аж ахуйн бүх ажил, гүйлгээ”*, 14.4.3 *“бүх өр төлбөр”*, 20 дугаар зүйлийн 20.2.5-т *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 20.2.6-д *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 4.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил аригуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Алтай сумын Эргэлтийн эмийн сан нь тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж, Эрүүл мэндийн төвийн Эргэлтийн эмийн сангийн ХААН банк дахь 5181020896 тоот дансаар гүйлгээ хийж ирсэн байна.

Нягтлан бодогчийн тооцоогоор Эргэлтийн эмийн сан нь 2021 онд эм хангамжийн 3 компаниас нийтдээ 68894.6 мянган төгрөгийн эмийг орлого авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн хөнгөлөлтийн санхүүжилтээс 40336.0 мянган төгрөг авч, эмийн хөнгөлөлтийн эмийн борлуулалтаас 18527.5 мянган төгрөгийг дансанд оруулсан байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын санд 2021 онд өгсөн нэхэмжлэлд хөнгөлөлтэй эмийн борлуулалтаас 23260.3 мянган төгрөг оруулахаар тайлагнасан боловч 21022.8 мянган төгрөгийг дансанд оруулж 4175.0 мянган төгрөгийг дутуу оруулсан байна.

2.Сумын Засаг даргын шийдвэрээр Эргэлтийн эмийн сангийн хяналтын зөвлөл байгуулж ажиллуулаагүй, Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Эргэлтийн эмийн сангийн удирдах зөвлөл шийдвэрлэхээр заасныг зөрчиж Эргэлтийн эмийн сангийн эмийн санч орлого авсан эмийн худалдах үнийг өөрөө тогтоож орлого авдаг, үйл ажиллагаанас бий болсон орлогыг юунд зарцуулж байгааг тогтоох боломжгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 630.4 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 529.2 сая төгрөгийн 103 мэдээллийг хугацаандаа байршуулж, 14 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Шилэн дансны мэдээллийн мэдээлсэн байдлын дундаж 91.7 хувьтай байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын Эрүүл мэндийн төв	4	115,0			2	9,6	1	4.2	1	101,2